МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/07 Мандалговь

Газар эзэмшүүлэх хэмжээ
өөрчлөх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 3.2 дахь заалт, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн XX.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн XX.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад заасан 2 байгууллагад 60017 м.кв (6 га) газрыг эзэмшүүлсүгэй.

Хоёр. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтад заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Дээрх байгууллагуудтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488010018

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 дугаар сарын 07 өдрийн А/07 тоот захирамжийн 1дүгээр хавсралт

| № | Эзэмшигчийн | | | Өмнөх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Захирамжийн | | Газрын | | | | | |
| | Төрийн байгууллагын | Улсын бүргэлийн дугаар | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ/м2/ | Хамжээ/м2/ | Байршил | Ашиглалтын зориулалт | Эзэмшүүлэх хугацаа |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 7 | 8 | 9 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв | 870001046 | 9033866 | 2011.10.31.А/525 | | 111600540 | 25000 | 46544 | Мандал сургуулийн хойд талд Г.Чандаржавын гудамж-4-400 | Төрийн үйлчилгээ | 23 |
| 2 | Дундговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв | 870001029 | 9033839 | 2006.10.24.310 | Холбогдох хэсэг | 111600056 | 365 | 13473 | Нисэхийн баруун талд | Төрийн үйлчилгээ | 30 |
| | нийт | | | | | | 25365 | 60017 | | | |